



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.09.16 № 01/1912

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240101119 дугаартай “Цанхийн зүүн уурхайн нүүрс ачилтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт: 01 хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124051041



Тодруулгын хариу

Тендерийн нэр	Цанхийн зүүн уурхайн нүүрс ачилтын ажил
Тендерийн дугаар	ЭТТХК/20240101119
Тендер зарласан огноо	2024 оны 08 дугаар сарын 21
Тендер нээх огноо	2024 оны 09 дүгээр сарын 19
Тодруулга №1	
Тодруулга	Хариу
ТШЗ-н 19.1- т “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Шаардана/” гэж 6м ³ -с дээш утгуурт ачигч гэдэгт 6 м ³ -с дээш ямар ч хэмжээтэй утгуурт ачигч гэж ойлгох уу?	6 м ³ утгуурын багтаамжтай дугуйт ачигч: Бүхий л уул уурхайн тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн албан ёсны техникийн үзүүлэлт, үйлдвэрийн гарын авлагад заасан утгуурын багтаамжийн үзүүлэлт 6 м ³ -с багагүй байхаар тусгасныг тооцно. Утгуурын багтаамжийг үйлдвэрлэгчээс заасан үзүүлэлтээс нэмж гагнуурын болон бусад аргаар томруулсныг тооцохгүй.
Тодруулга №2	
Тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-ын 2.2-т “Үйлдвэрлэгчээс гаргасан техникийн үзүүлэлт бүхий каталоги танилцуулга, албан ёсны үйлдвэрлэгчийн веб сайтын мэдээллийн хамт ирүүлнэ.” гэж заасан. /Дамжуулан борлуулах эрхтэй аж ахуй нэгжийн веб сайт дээрх мэдээллийг үнэлгээнд харгалзан үзэхгүй болно./	